



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/06

Баян-Овоо сум

Дотоод хяналт шалгалт хариуцсан ажлын
хэсгийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай журам" - ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн дотоод хяналт шалгалт хариуцсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганцэцэг

Номын санч

Гишүүн: П.Болортуяа

Сургалтын менежер

Ч.Гансувд

Бага ангийн багш

Б.Ганзул

Хоолзүйч

Нарийн бичгийн дарга: Э.Оюунтунгалаг

Дизайн технологийн багш

2. Сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөх, хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг хамт олонд мэдээлж ажиллахыг дотоод хяналтын ажлын хэсгийн ахлагч (Б.Ганцэцэг)-т даалгасугай.

3. Ажлын хэсгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, захиргааны зөвлөлд хэлэлцүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганцэцэг), нарийн бичгийн дарга (Э.Оюунтунгалаг) нарт даалгасугай.

4. Уг тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 09 сарын 12-ны өдрийн А/42 тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА



2328010031